

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ**


2020 оны 03 дугаар сарын 23


Багануур дүүрэг

№	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	2020 онд хүрэх түвшин, үр дүн	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ /сая.төг/, хөрөнгийн эх үүсвэр	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээний хувь
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ӨРХ БҮРТ								
1.1. Үйлдвэрлэл, инновацийг цогцоор нь хөгжүүлнэ.								
1-4	1.1.1.4. Багануур дүүрэгт үйлдвэрлэл, технологийн байгуулах эхлүүлнэ. Багануур “Багануур парк” ажлыг	“Багануур Үйлдвэрлэл, технологийн парк”-ийн дэд бүтцийн ажлыг барьж байгуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ.	НШУУИГ, НХБХГ, БҮТП ОНӨТҮГ	Хүнд үйлдвэрийн бүсийн дэд бүтцийн асуудлын шийдвэрлэлт хувь	100	Төр, хувийн хэвшлийн түншлэл	25	
			НШУУИГ, НХБХГ, БҮТП ОНӨТҮГ	Цахилгаан хангамжийн ажлын явц, хувь	50	9,376.9 Гадаадын эх үүсвэр		
		1. Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч, төлөөлөгчдийн 2020 оны 02 дугаар улирлын хурлаар Парк хөгжүүлэх сан байгуулах, паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалттай холбогдсон асуудлыг хэлэлцүүлэх саналыг Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 16-ны 14 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.						
2. Паркуудийн үйл ажиллагааг эрчимжүүлэх томоохон ажлуудыг зохион байгуулж, хамтран ажиллах зорилготой Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газрын дарга Б.Мөнх-Оргилд байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн үр дүн, цаашдын зорилго, зорилтууд мөн тулгамдсан асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг “Багануур Үйлдвэрлэл,	25							

	технологийн парк” ОНӨТҮГ-ын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 29 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.		
	3. Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тодотгол хийх гэж байгаатай холбогдуулан Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газарт Багануур Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтад шаардлагатай санхүүжилтийн саналыг, салбарын өнөөгийн байдал, 2019 оны ажлын гүйцэтгэл, ТЭЗҮ, ТЭЗҮС, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний тайлбар зэрэг шаардлагатай бусад материалын хамт “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 24 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	25	
	4. 2020 оны Нийслэл болон Улсын төсвөөс Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтанд ямар нэгэн хөрөнгө санхүүжилт олгогдоогүй. Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн өндөр хүчдэлийн 4,2км агаарын шугам эхний ээлжинд байгуулах чухал шаардлагатай. Энэхүү төслийн саналыг хөрөнгө оруулагч нарт санал болгосноор “МЕСЕС” ХХК-иар гүйцэтгүүлэхээр 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр БҮТП-ийн Хуулийн зөвлөх С.Отгонбаатар, “МЕСЕС” ХХК-ийн удирдлага болон “Мон-энержи Консалт” ХХК-ийн Бизнес хөгжлийн захиралтай хамтын ажиллагааны гурвалсан гэрээг байгуулан ажиллаж байна. Тус компани нь Паркийн цахилгаан хангамжийн трассыг ашиглан өөрийн үйлдвэрийн цахилгаан хангамжийг байгуулах ба хоёр талын хамтын ажиллагааг дээрх гэрээгээр баталгаажуулсан болно. Эхний ээлжинд шаардлагатай бүх зардлыг тус компани гаргаж 4,2км цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн агаарын шугамыг байгуулж манай Паркийн эзэмшилд бүрэн шилжүүлэн өгөх юм. Паркийн зүгээс дээрх зардлын 50%-ийг Нийслэлийн төсвийн тодотголоор оруулах санал тавьж, дүүргийн болон нийслэлийн Засаг дарга нарын хэмжээнд урьдчилсан байдлаар шийдвэрлүүлсэн. Багануур Үйлдвэрлэл, технологийн парк нь уг гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд “МЕСЕС” ХХК нь цахилгаан хангамжийн трасс, төлөвлөлтийг гүйцэтгэгч байгууллага мөн дүүргийн газрын алба болон хангагч байгууллагуудтай зөвшилцөн ерөнхий схемийг боловсруулсан. Одоогийн байдлаар шаардлагатай техникийн нөхцөлийг гаргуулахаар Барилга хот байгуулалтын яамнаас Эрчим хүчний Сайдад 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/685 дугаартай албан бичгээр хандаад байна.	40	
	5. “Багануур” ХК-ий үйлдвэрийн бүсийн дэд бүтцийг түшиглэн Багануур Үйлдвэрлэл, технологийн паркийн хүнд үйлдвэрийн бүсийн бүтээн байгуулалтад шаардлагатай зардал, төсвийг бууруулж, цаг хугацааг хэмнэх үүднээс “Багануур” ХК-тай хамтран ажиллах боломжийг судалж, зарим шаардлагатай техникийн өргөтгөл хийж, ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар эрчим хүч, дулаан, төмөр зам болон авто замыг ашиглах судалгааны	25	

	ажил хийж байна. “Багануур” ХК-тай хамтран ажиллах нь олон талт ашигтай боловч, мөн үүсч болох эрсдэлүүдийг маш нарийвчилсан түвшинд тодорхойлох нь чухал байна.		
	<p>6. ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын Даргын 2019 оны 47 тоот тушаалын 02 дугаар хавсралтын дагуу Багануур Үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхлүүлэн ажиллаж байна.</p> <p>7. Байгууллагын дүрмийг шинэчлэн боловсруулж, НИТХ-аар батлуулахаар бэлтгэж байна.</p> <p>8. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журмын 3.4 / Паркийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн дагуу эрдэм шинжилгээ, судалгаа явуулах нэгж, технологийн инкубатор төв байгуулах/ заалтын дагуу ХААИС, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, ШУТИС, ШАУИС-иудтай 2019 онд байгуулсан хамтын ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, 2020 оны төлөвлөгөөт ажлуудыг эхлүүлэн ажиллаж байна.</p> <p>9. Паркийн бүсүүдэд хөрөнгө оруулах төслүүдийн саналыг хүлээн авах, зөвлөгөө өгөх, мөн Улаанбаатар хотод зохион байгуулагддаг техник технологийн үзэсгэлэн яармаг, хөрөнгө оруулагчдын уулзалт, зөвлөгөөнүүдэд оролцож, өөрийн Паркийн үйл ажиллагааг сурталчлан оролцох зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. 2020 оны 03 сарын 04-ний өдөр цэвэрлэх байгууламжийн лагийг бордоо болгон үйлдвэрлэх технологийн мэдээллийг “Эко Тайхи” ХХК-ий менежер Ш.Болдсайхан-аас авч, хот хаягдлаар бордоо үйлдвэрлэдэг технологитой хоршуулах боломжийн талаар санал солилцов.</p>	25	

БИЕЛЭЛТ ХЯНАСАН:
 БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА  Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Б.НОМИНЗУЛ

